

## ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР ТӨЛӨГЧДИЙН ТАТВАРААС ЗАЙЛСХИЙХ ХАНДЛАГАД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛИЙН ШИНЖИЛГЭЭ /Орхон аймгийн жишээн дээр/

Л.Наранчимэг\*, Э.Вандандулам\*\*, Г.Цэвэгсүрэн\*\*\*

**Хураангуй:** Монгол улсын хэмжээнд хувиараа бизнес эрхлэгчид иргэдийн татварын тайлангийн ирц бага, татвараас зайлсхийх хандлагатай байгаа тул энэхүү судалгаа нь татвар төлөгчдийн татвараас зайлсхийх хандлагад нөлөөлж буй хүчин зүйлсийг судлах зорилготой. Бид Орхон аймгийн хувиараа бизнес эрхлэгч 150 иргэнээс асуулгын аргаар судалгааг авч цуглуулсан мэдээллийн бүтцийн тэгшитгэлийн загварчлалыг (SEM) ашиглан дүгнэлт гаргасан. Татварын шударга ёсны талаарх ойлголт, авлига, татварын хяналт шалгалт, хяналт шалгалтын дараа татварын албаны хэрэгжүүлж буй ажлууд, татварын байгууллагын үр ашиг зэрэг үзүүлэлтүүд Орхон аймгийн ХХОАТ төлөгч иргэдийн татвараас зайлсхийх хандлагад нөлөөгүй гэж тодорхойлогдлоо.

Харин татварын ялгаварлан гадуурхалт, татварын мэдлэг, татварын тогтолцооны нарийн төвөгтэй байдал зэрэг нь татвараас зайлсхийхэд эерэг нөлөөтэй байна. Мөн иргэдийн татвараас зайлсхийх хандлагад хүн ам зүйн шинжүүд нь хэрхэн нөлөөлж байгааг судлахад хүйсийн байдал нөлөөгүй, боловсролын түвшин дээшлэх нь эерэг нөлөөтэй байна.

**Түлхүүр үгс:** татвар төлөгчийн хандлага, татварын шударга байдал, бүтцийн тэгшитгэлийн загварчлал, татварын тогтолцооны нарийн төвөгтэй байдал

## ANALYSIS OF FACTORS AFFECTING THE TAX AVOIDANCE ATTITUDE OF PERSONAL INCOME TAX PAYERS /On the example of Orkhon province/

**Abstract:** The purpose of this study is to investigate the factors that affect the tendency of taxpayers to avoid taxes because there is a low tax reporting and there is a tendency to avoid taxes among the self-employed business owners in Mongolia. We made a conclusion using structural equation modeling (SEM) of the data collected by surveying 150 self-employed entrepreneurs operating in Orkhon province. Indicators such as the awareness on tax fairness, corruption, tax inspections, activities carried out by the tax authority after the inspection, as well as the efficiency of tax organizations have been determined to have no impact on the tax avoidance attitude of the tax payers of Orkhon province.

Tax discrimination, tax knowledge, and the complexity of the tax system have a positive impact on tax avoidance. In studying how demographic characteristics affect citizens' tendency to avoid taxes, it has been found that the gender has no impact, and the level of education has a positive impact.

**Keywords:** taxpayer attitudes, tax fairness, structural equation modeling, complexity of the tax system

\* МУИС, Бизнесийн сургууль, (E-mail): [Lnaraa9191@gmail.com](mailto:Lnaraa9191@gmail.com)

\*\* “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын дэргэдэх, ШУТИС-ийн харьяа Эрдэнэт цогцолбор дээд сургууль, (E-mail): [vandandulam@erdenetis.edu.mn](mailto:vandandulam@erdenetis.edu.mn)

\*\*\* “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын дэргэдэх, ШУТИС-ийн харьяа Эрдэнэт цогцолбор дээд сургууль, (E-mail): [g.tsevegsuren@gmail.com](mailto:g.tsevegsuren@gmail.com)

## ОРШИЛ

Хувь хүний орлогын албан татвар (ХХОАТ)-ын тухай хуульд хөдөлмөр эрхлэлтийн орлого, үйл ажиллагааны орлого, хөрөнгө ба хөрөнгө борлуулсны болон бусад бүх орлогыг татварын суурьт хамруулан татвар төлөхөөр заасан хэдий ч ХХОАТ-ын орлогын 70-75 хувийг нь зөвхөн цалин, хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлого бүрдүүлж, үйл ажиллагааны орлогоос төлсөн татварын дүн 4-6 хувийг эзэлж байгаагаас үзэхэд бусад төрлийн орлого олсон иргэд хангалттай татварт хамрагдахгүй, ХХОАТ-ын ачааллыг тогтмол ажлын байртай, гэрээгээр хөдөлмөр эрхэлж буй хүмүүс үүрч, татварын шударга байх зарчим хангагдаж чадахгүй байх магадлалтайг харуулж байна (Нээлттэй нийгэм форум, 2023). Үйл ажиллагааны орлого нь иргэн худалдаа, арилжаа, үйлдвэрлэл, үйлчилгээг хуулийн этгээд үүсгэхгүйгээр эрхэлж олсон орлого хамаарагдана. Худалдаа арилжаа эрхлэх гэдэг нь зах дээр ажлын байртай бараа, бүтээгдэхүүнийг бусдаас авч борлуулах эсвэл өөрийн зүгээс бүтээгдэхүүн үйлдвэрлэн борлуулах, гоо сайхан, үсчин, эмнэлэг, сургалт, валют арилжаа, тээвэр зэрэг үйлчилгээг үзүүлэх ажлуудыг иргэд хэрэгжүүлдэг (Г.Алтанзаяа, 2023). Татварын ерөнхий газрын мэдээгээр 2022 оны байдлаар 2,092.0 мянган ХХОАТ төлөгч байгаагаас 331.1 мянган татвар төлөгч тайлангаа ирүүлсэн нь 15%-ийн ирцтэй байна (Татварын ерөнхий газар, 2023). Иймээс татвар төлөгч иргэдийн татвараа өөрөө тодорхойлж, холбогдох байгууллагад илгээх хандлага тааруу, татвараас зайлсхийх хандлагатай байгааг харуулж байна. Энэхүү судалгаандаа Орхон аймгийн ХХОАТ-ын үйл ажиллагааны орлогоор татвар төлөгч иргэдийн татвараас зайлсхийх хандлагад нөлөөлөх хүчин зүйлийг тодорхойлж, дүгнэлт гаргахын зорилго.

## ОНОЛЫН ХЭСЭГ

### ХХОАТ-ын хууль, эрх зүйн орчин

Монгол улсын ХХОАТ-ын тухай хууль нь дэлхийн бусад улс орнуудын нэгэн адилаар дээрх нийтлэг зарчимд үндэслэгдсэн байдаг ба хүн бүр, жил бүр өөрийн олсон орлого, хөрөнгөө тайлагнаж татвар ногдуулах үүрэг хүлээнэ. Монгол улсын ХХОАТ-ын тухай хуулийн 6.3-д зааснаар хувь хүний орлогод дараах татвар ногдуулна.

1. Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого
2. Үйл ажиллагааны орлого
3. Хөрөнгийн орлого
4. Хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого


5. Шууд бус орлого
6. Бусад орлогоос тус тус бүрдэнэ.

ХХОАТ- тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2019 оны 03-р сарын 22-ны өдөр баталж 2020 оны 1-р сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн. Тус хуулийн онцлог нь 15 дугаар зүйлийн 15.6-д Хувь хүн өөрөө хүсэлт гаргаж, уг хүсэлтийг харьяа татварын алба бүртгэж авсан бол түүний үйл ажиллагааны орлогын нийт дүнгээр албан татвар ногдуулах орлогыг тодорхойлж болно гэж хуульчилсан бөгөөд үүнийг Татварын алба “Хялбаршуулсан горим ашиглах” гэж нэрлэж үйл ажиллагаанд хэрэгжүүлж байна.

### **Татвар төлөгчдийн татвараас зайлсхийх хандлага**

Хандлага гэдэг нь үнэлж болохуйц аливаа зүйлд хүмүүсийн дуртай болон дүргүй байх нөхцөл байдлыг хэлнэ (Paul H. P. Hanel, 2024). Ерөнхийдөө хувь хүмүүсийн хандлага нь тэдний мэдлэг ойлголтоос үүдэлтэй байдаг тул татвараас зайлсхийхэд хандлага, ойлголтыг харилцан адилгүй ашигладаг (Chan Pui Yee, 2017). Татварын ёс зүйтэй сайн татвар төлөгч байхын тулд тэдний төлсөн татварын зарцуулалт үр ашигтай, төрийн байгууллага авлигагүй, татварын тогтолцоо шударга, татварын хэмжээ хэт өндөр биш, хяналт шалгалт сайн, буруутай этгээдэд торгуул алдангийг ногдуулдаг байх тогтолцоог бүрдүүлж, төр татварын тогтолцоонд хутгалдахаа больж итгэлцлийн соёлыг бий болгох хэрэгтэй (Fadi Al-Asfour, 2023). Татвар төлөгчдийн татвараас зайлсхийх хандлагад татварын шударга байдал, ялгаварлан гадуурхалт, авлига, татварын боловсрол, татварын тогтолцооны төвөгтэй байдал, татварын хяналт шалгалт, татварын албаны хэрэгжүүлдэг ажлууд, татварын албаны үр ашигт байдал зэрэг хүчин зүйл нөлөөлнө. Эдгээр хүчин зүйлд хүн ам зүйн нас хүйс, боловсрол, гэр бүлийн байдал, ажил эрхлэлт, орлогын түвшин нөлөөлнө (Harun Ur Rashid, 2020).

**Зураг 1. Татвар төлөгчдийн татвараас зайлсхийх хандлагын загвар**  
Эх сурвалж: (Harun Ur Rashid, 2020)



### 1. Татварын шударга байдал

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас дэлхийн 100 гаруй улсад явуулсан Дэлхийн үнэ цэний судалгаагаар татварын ёс зүй болон татварын биелэлтийн хоорондын хамаарлыг гаргаж ирсэн. Татварын ёс зүй нь далд эдийн засгийг гол тодорхойлогч төдийгүй татвараас зугтаах байдал нөлөөлдөг. Түүнчлэн татварын ёс зүй нь татварын биелэлтэд голлох нөлөөг үзүүлдэг ба ард иргэдийн татварын тогтолцоонд хандах хандлагыг тодорхойлж байдаг гэж үзжээ.

Харун Ур Рашидын тодорхойлсноор (Harun Ur Rashid, 2020) татварын шударга байдал гэдэг нь татвар төлөгчид ногдуулсан татвараа төлөх, татварын албатай хамтран ажиллах, хуулийг дагаж мөрдөх хүсэл эрмэлзэл бөгөөд үүний үр дүнд татвараас зайлсхийх явдал багасдаг гэж тодорхойлжээ.

Иймээс энэхүү судалгаа нь татвар төлөгчдийн шударга байдлын талаарх ойлголт болон татвараас зайлсхийх хандлага хооронд сөрөг хамааралтай гэж үзэж дараах таамаглал дэвшүүлсэн.

**Таамаглал 1 (H1)** - Татварын шударга байдал нь татвараас зайлсхийхэд сөргөөр нөлөөлдөг.

### 2. Ялгаварлан гадуурхах байдал

Монгол улсын Татварын ерөнхий хууль болон Үндсэн хуульд иргэдийг шашин шүтлэг, арьс өнгө, үндэс угсаа, нийгэмд эзлэх байр суурь зэргээр нь ялгаварлан гадуурхгүй байхаар заасан байдаг. Хэдийгээр тийм боловч 2019 онд ОРХОН аймгийн 330 бизнес эрхлэгчдийн дунд хийсэн судалгаагаар 100% заримдаа

ялгаварлан гадуурхалт тохиолддог гэж хариулжээ (Л.Буяндулам, 2019). Иймээс татварын ялгаварлан гадуурхах хандлага нь татвараас зайлсхийх хандлагад эерэг нөлөөтэй гэсэн таамаглал дэвшүүлж байна.

Таамаглал 2 (Н2) – Ялгаварлан гадуурхах байдал нь татвараас зайлсхийх хандлагыг дэмжих нөлөөтэй.

### **3. Авлига**

Монгол улсын хувьд татвар төлөхөөс зайлсхийгчид Эрүүгийн хууль болон Зөрчлийн хуулийн хоорондын зөрчилтэй байдал, эрх зүйн зохицуулалтын хийдлийг ашиглан хариуцлагаас зайлсхийх явдал гаргасаар байгаа. Эрүүгийн хууль болон Зөрчлийн хууль хоёрын нэг төрлийн харилцааг зохицуулсан зохицуулалтын зөрчилтэй байдлын уршгаар сүүлийн үед харин ч цагдаагийн байгууллагаар шалгуулахаар нэг ч мөнгөний торгуульгүй өнгөрөөд зогсохгүй, нөгөө их хэмжээний нуун дарагдуулсан татвар дахин сөхөгдөхгүйгээр хаагдаж хариуцлагаас мултрах тохиолдол их болжээ (Г.Хишигсүрэн, 2022).

Хувийн секторын хөрөнгө оруулалтын шийдвэр эдийн засгийн ашигтай ажиллагааны төлөө бус харин хувийн болон төсвийн секторын авлигад идэгдсэн шийдвэр гаргагчдыг хахуульдахад зарцуулагдаж байж магадгүй. Үүний зэрэгцээ улс төрийн авлига нь төрийн татвараас олох орлого ба мөнгөний урсгалыг тасалдуулах аюултай. Хахуульд автсан татвар хураагчид татварын төлбөрийн хэмжээг эрс бууруулдаг (Марк Саксер, 2020).

Үүний дагуу уг судалгаанд авлига болон татвараас зайлсхийх хоёрын эерэг хамаарлыг санал болгож, дараах таамаглал дэвшүүлжээ.

Таамаглал 3 (Н3) - Авлига нь татвараас зайлсхийхэд эерэг нөлөө үзүүлдэг.

### **4. Татварын боловсрол**

Иргэн бүр татвараа үнэн зөв тодорхойлж, цаг хугацаанд нь төлснөөр улс орны эдийн засгийг хөгжүүлэх, улмаар нийгмийн ард иргэдийн амьдралын түвшнийг дээшлүүлэх, сайн сайхан амьдрах нөхцөл боломжийг хангах санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэхэд Засгийн газартаа тусалж байна гэсэн үг (Монгол банк, 2019). Татварын боловсрол нь тухайн улсын татварын тогтолцоо, татварын хууль тогтоомжийн талаарх ойлголтыг өгдөг.

Татварын талаарх суурь мэдлэг нь татвар төлөгчдөд татварын хууль тогтоомжийг сайн дураараа дагаж мөрдөхөд нөлөөлдөг тул татвараас зайлсхийх боломжийг бууруулна (Marziana Mohamad, 2013). Иймээс тус судалгаанд дараах таамаглалыг дэвшүүлж байна.

Таамаглал 4 (Н4) - Татварын мэдлэг нь татвараас зайлсхийхэд сөргөөр нөлөөлдөг.

## **5. Татварын тогтолцооны нарийн төвөгтэй байдал**

Татварын тогтолцоо илүү төвөгтэй болох үед дагаж мөрдөх зардал ч өндөр болно. Татварын нарийн төвөгтэй системүүд нь татвар төлөгчдөөс нэмэлт сургалтад хамрагдахаас гадна гаднаас мэргэжлийн зөвлөгөө авахыг шаарддаг. Иймээс татварын нарийн төвөгтэй байдал нь татварыг дагаж мөрдөхөд шууд болон шууд бусаар нөлөөлдөг (Musimenta, 2020).

Дэлхийн 45 орны мэдээлэлд үндэслэн судалгааны үр дүнгээс харахад эдийн засгийн бус тодорхойлогч хүчин зүйлүүд татвараас зайлсхийхэд хамгийн хүчтэй нөлөө үзүүлдэг. Ялангуяа татварын нарийн төвөгтэй байдал нь татвараас зайлсхийх хамгийн чухал хүчин зүйл юм. Ерөнхийдөө судалгааны үр дүн нь татварын нарийн төвөгтэй байдлын түвшин бага байх тусам боловсрол, үйлчилгээний орлогын эх үүсвэр, шударга ёс, татварын ёс суртахууны түвшин өндөр байх тусам татвараас зайлсхийх явдлыг багасаж байгааг харуулж байна (Richardson, 2016). Иймээс татварын нарийн төвөгтэй байдал, татвараас зайлсхийх хандлагын хооронд эерэг хамаарал байна гэж үзэж дараах таамаглалыг дэвшүүлж байна.

*Таамаглал 5 (H5)* - Татварын тогтолцооны нарийн төвөгтэй байдал нь татвараас зайлсхийхэд эерэг нөлөө үзүүлдэг.

## **6. Татварын хяналт шалгалт**

Монгол улсын хэмжээнд аж ахуй нэгж байгууллагын хувьд хяналт шалгалтыг татварын скоринг үнэлгээгээр онлайнаар тооцоолж эрсдэлийн хүчин зүйлийг тооцож, хяналт шалгалтыг гүйцэтгэж байна. ХХОАТ төлөгчдийн хувьд одоогоор татварын системд нэвтрээгүй байгаа ч Татварын Ерөнхий хуулийн эрсдэлийн удирдлагын систем, татвараас зайлсхийх эсрэг ерөнхий дүрэмд зааснаар татвар төлөгчдийн эрсдэлийн үнэлгээг хийх шаардлагатай. Татварын хуульд зааснаар татварын хуульд зайлсхийсэн татварыг нөхөн төлүүлэхээс гадна хүү, торгуул ногдуулдаг. Иймд шалгалт болон татвараас зайлсхийх хоёрын уялдаа холбоог судлахын тулд судалгаанд дараах таамаглал дэвшүүлж байна.

*Таамаглал 6 (H6)* - Татварын хяналт шалгалт хийх нь татвараас зайлсхийхэд сөргөөр нөлөөлдөг.

## **7. Татварын албаны хяналт шалгалтын үр дүнгээр хэрэгжүүлдэг ажлууд**

Татварын ерөнхий хуульд зааснаар Татвар төлөгч нь татвар төлөхгүй байх, төлөх татварын хэмжээг бууруулах, эсхүл татвар ногдох зүйлийг нуух зорилгоор татвар ногдуулаагүй буюу татварын ногдлыг бууруулсан бол татварын улсын байцаагч татварыг нөхөн төлүүлж, торгуул, алданги ногдуулна” гэж заасан.

Энэ нөхцөл нь татвараас зайлсхийх хандлагыг бууруулах хөшүүрэг болно. Татвар төлөгчид татварын тогтолцоог дагаж мөрдөх эсэх нь хяналт шалгалтын дараа эрх бүхий байгууллагаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээнээс ихээхэн хамаардаг (Susanna Calimani, 2014). Иймээс дараах таамаглалыг дэвшүүлж байна.

**Таамаглал 7** (H7) - Татварын албаны хэрэгжүүлж буй ажлууд нь татвараас зайлсхийхэд сөргөөр нөлөөлдөг.

### **8. Татварын албаны татвар төлөгчдөд үзүүлэх үр ашиг**

Татварын байгууллага татвар төлөгчдөд зөвлөн туслах үйлчилгээг хангалттай сайн үзүүлснээр татвараас зайлсхийх хандлагыг бууруулна. Татвар төлөгчид зориулж татварын албанаас цахим, танхим, лавлах утсаар зөвлөгөө өгөх зэргээр олон төрлийн сургалтуудыг зохион байгуулж байна. Ирээдүйд татварын тухай тодорхой мэдлэгтэй татвар төлөгчдийг бий болгохын тулд сургуулийн өмнөх наснаас нь эхлэн дээд сургууль төгстөл нь татварын тухай ойлголтыг системтэйгээр олгох хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, хэдий чинээ татварын талаар эрт ойлголт өгнө төдий чинээ татварын тухай мэдлэгтэй татвар төлөгчид ирээдүйд төрөн гарна (Г.Сарангэрэл, 2012). Татвар төлөгчдийн татварын албаны талаарх ойлголт нь сайн, татварын байцаагч нар мэргэжлийн, мэдлэгтэй, туслахад бэлэн, хүндэтгэлтэй байвал татвар төлөгчдийн ёс зүй өндөр, татвараас зайлсхийх хандлага буурдаг талаар гаднын олон судлаачдын судалгаанд дурджээ.

**Таамаглал 8** (H8) - Татварын байгууллагын үр ашиг нь татвар төлөгчдийн татвараас зайлсхийх хандлагад сөргөөр нөлөөлдөг

Бид дээр дэвшүүлсэн 8 таамаглалын үр дүнг Warp PLS 7.0 программын тусламжтайгаар хамгийн бага квадрат Бүтцийн тэгшитгэлийн загварчлал (Structural Equation Modeling)-ын тоон аргаар цуглуулсан өгөгдөлд дүн шинжилгээ хийж тодорхойлно.

### **Бүтцийн тэгшитгэлийн загварчлал (Structural Equation Modeling)**

Бүтцийн тэгшитгэлийн загварчлал (SEM) нь тодорхойдогдсон хувьсагчид болон далд хувьсагч хоорондын хамаарлыг тодорхойлох боломжийг олгодог нарийн статистикийн арга юм.

Бүтцийн тэгшитгэлийн загварчлалд хэд хэдэн нэгдсэн статистик аргууд байдаг. Үүнд ихэвчлэн вариацийн шинжилгээгээр бүлэг хоорондын болон бүлэг доторх хэлбэлзлийн харьцуулалтыг тооцно. Нэг эсвэл хэд хэдэн хувьсагчдын бусдад үзүүлэх нөлөөллийг илэрхийлэх загварыг тодорхойлж тэдгээрийн харилцааг тооцоолох боломжтой замын шинжилгээ (регрессийн шинжилгээ) нь хувьсагчдын хоорондын таамагласан учир шалтгааны хамаарлыг илэрхийлнэ.

Эдгээр дүн шинжилгээг корреляци, ковариаци өгөгдөл ашиглан хийж болно. Дээрх шинжилгээг хийхийн тулд судлаач бүтцийн болон хэмжилтийн загварыг аль алийг нь боловсруулах шаардлагатай.

**Бүтцийн загвар** нь далд хувьсагчдын хоорондын хамаарлыг илэрхийлдэг бөгөөд тэдгээрийн хамаарлын зэргийг (замын коэффициент  $\beta$ -г тооцдог) тодорхойлох боломжийг олгодог. Замын коэффициентын утгууд нь “-1-ээс +1” хүртэлх мужаас бүрдэнэ. Замын коэффициентын утгаар “+1-д ойр” гэсэн хүчтэй эерэг хамаарал, “-1-д ойр” замын коэффициентын утгаараа илүү хүчтэй сөрөг хамаарал байгааг илэрхийлнэ (Sajjad Ahmad Baig, 2023). Бүтцийн тэгшитгэлийн коэффициент бүрийг тооцоолохын зэрэгцээ бусад бүх хэлбэлзлийг харгалзан үздэг. Иймээс коэффициентыг энгийн олон регрессийн загварууд шиг дараалсан бус харин бүх эндогени хувьсагчдын хувьд нэгэн зэрэг тооцдог.

**Хэмжилтийн загвар** нь ажиглагдсан хувьсагчид тус тусын далд бүтэцтэй хэрхэн холбогдож байгааг тодорхойлдог бөгөөд үндсэндээ онолын үзэл баримтлалын үйл ажиллагааг тодорхойлдог. Судалгаанд ихэвчлэн хэрэглэгддэг хэмжсэн хувьсагчид болон далд хувьсагчаас бүрдэнэ. Далд хувьсагч гэдэг нь хүчин зүйлийн шинжилгээний үр дүнд бий болсон дор хаяж хоёр харилцан хамааралтай хэмжигдэхүүн хувьсагчаас бүрддэг. Тэдгээрийг шууд хэмждэггүй, харин хэмжсэн хувьсагчдын давхцаж буй дисперсээр илэрхийлэгддэг тул далд гэж нэрлэдэг. Эдгээр нь хэмжилтийн алдаа багатай тул хэмжсэн хувьсагчаас илүү судалгааны бүтцийг илүү сайн төлөөлдөг гэж үздэг. Загвар боловсруулах, дүн шинжилгээ хийхэд дараах алхмуудыг хэрэгжүүлнэ.

1. Судалгааны асуудлыг тодорхойлох
2. Загварыг тодорхойлох
3. Загварын тооцоолол
4. Загварын тохирох байдлыг тодорхойлох
5. Шаардлагатай бол загварыг дахин сайжруулна.

## СУДАЛГААНЫ ХЭСЭГ

2023 оны байдлаар Орхон аймагт төвлөрсөн төв болон багуудад үйл ажиллагаа эрхэлж байгаа борлуулалтын орлого болон худалдан авалттай 12650 бизнес эрхлэгч бүртгэлтэй байна.

Бид Орхон аймгийн ХХОАТ төлөгч 150 бизнес эрхлэгчээс асуулгын аргаар судалгаа авч судалгааны үр дүнг Warp PLS 7.0, SPSS програмуудын тусламжтай боловсруулсан.

**Нэг.** Татвар төлөгчдийн хүн ам зүйн шинжийг судлах зорилгоор дараах үзүүлэлтүүдийг тодорхойллоо.

1. Бизнес эрхлэгчдийн гэр бүлтэй эсэх нь орлогоо тодорхойлж тайлагнаж байгаад хэрхэн нөлөөлж байна вэ?



Хүснэгт 1. Татвар төлөгчдийн гэр бүлийн байдал  
( татвар тайлагнаж төлсөн хугацаагаар)

Үзүүлэлт		Та хэдэн жил ХХОАТ-ын орлогоо тайлагнаж татвараа төлсөн бэ?					Total
		Татвар төлөгч биш	1-2 жил	2-4 жил	4-6 жил	7 дээш жил	
Та гэр бүлтэй юу?	Тийм	25	15	23	34	21	118
	Үгүй	18	5	2	6	1	32
Total		43	20	25	40	22	150

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Нийт судалгаанд оролцогчдын 28.6% (43) нь татвар төлөгч биш бөгөөд эдгээрийн 42% (18) нь гэр бүлгүй байна. Харин татвар төлөгчдийн 15% ((32-18)/(118-25)) нь гэрлээгүй байна. Иймээс татвар төлөгчөөр бүргүүлсэн иргэдийн дийлэнх олонх нь гэр бүлтэй байна. Дээрх үр дүнгээс харахад гэр бүлтэй бизнес эрхлэгчид хариуцлагатай өндөр, татвар төлөгчөөр бүртгүүлж орлогоо тодорхойлж тайлагнаж байна.

2. Бизнес эрхлэгчдийг орлогын түвшнийг 5 интервалд хувааж орлогын хэмжээг тодорхойллоо.

Хүснэгт 2. Татвар төлөгчдийн хүйс (жилийн орлогын хэмжээгээр)

Үзүүлэлт		Таны хувиараа эрхэлж буй үйл ажиллагааны жилийн орлого хэд вэ?				Total
		0-15000000	15000001-30000000	30000001-50000000	50000001-дээш	
Таны хүйс	Эрэгтэй	5	7	16	16	44
	Эмэгтэй	16	31	36	23	106
Total		21	38	52	39	150

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн 70% (106) нь эмэгтэйчүүд бөгөөд эдгээрийн 56% (36+23) нь 30 саяас дээш орлоготой байна. Харин эрэгтэйчүүдийн 73% (16+16) нь 30 саяас дээш орлоготой байна.

3. Бизнес эрхлэгчдийн боловсролын түвшин, татварын тайлангаа гаргаж байгаатай хэрхэн уялдаж байна вэ?

Хүснэгт 3. Татвар төлөгчдийн боловсролын түвшин  
(тайлан гаргадаг хэлбэрээр)

Үзүүлэлт		Татварын тайлангаа ихэвчлэн хэнээр гаргуулдаг вэ?						Total
		Үндсэн нягтлан бодогч	Бизнес эрхлэгч өөрөө	Санхүүгийн зөвлөгөө өгдөг байгууллагаар	Гэрээг нягтлан бодогч	Тайлан боловсруулдаг танил хүнээр	Тайлан гаргадаггүй	
Таны боловсролын түвшин	Суурь боловсрол	2	8	0	5	3	15	33
	Бүрэн дунд боловсрол	1	7	3	5	7	18	41
	Мэргэжлийн боловсрол	1	2	0	1	6	5	15
	Дээд боловсрол	3	21	4	10	13	9	60
	Магистр, түүнээс дээш	0	1	0	0	0	0	1
<b>Total</b>		7	39	7	21	29	47	150

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Нийт бизнес эрхлэгчдийн 40% (60) нь дээд боловсролтой бөгөөд өөрөө тайлангаа гаргадаг иргэдийн 54% (21) нь дээд боловсролтой иргэн байна.

4. Тайлангаа гаргаж, илгээдэггүй гэж хариулсан бизнес эрхлэгчдээс шалтгааныг тодруулахад дараах байдалтай байна.

Хүснэгт 4. Татвар төлөгчдийн хүйс (тайлан илгээхгүй байгаа шалтгаанаар)

Үзүүлэлт		ХХОАТ-ын татвар төлөгч биш, тайланг илгээхгүй байгаа шалтгаан юу вэ?					Total
		Тайлан илгээх мэдлэггүй	Тайлантай холбоотой мэдээлэлгүй	Компьютер дээр ажиллаж мэдэхгүй	Тайлан илгээхэд системийн ачаалал их	Тайлангийн маягтыг ойлгодоггүй.	
Таны хүйс	Эрэгтэй	4	2	4	1	5	16
	Эмэгтэй	10	6	8	1	6	31
<b>Total</b>		14	8	12	2	11	47

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Татварын тайлан илгээдэггүй иргэдийн ихэнх нь татварын тайлан илгээх мэдлэггүй, тайлантай холбоотой ямар нэгэн мэдээлэл авч чаддаггүй, тайлангийн маягтыг ойлгодоггүй гэж хариулсан нь тэдний татварын мэдлэг муу байгааг харуулж байна.

5. Бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааны чиглэл болон хасагдах зардлыг тодорхойлох баримтыг яагаад авч чадахгүй байгааг тодорхойлоо.

*Хүснэгт 5. Татвар төлөгчдийн үйл ажиллагааны чиглэл  
(худалдан авалтын баримт бүрдүүлдэг байдлаар)*

Үзүүлэлт		Та худалдан авалт буюу зардлын баримтаа хэрхэн яаж бүрдүүлдэг вэ?					Total
		Худалдан авалтын баримтаа авч чаддаг	Худалдан авалтын баримтаа авч чаддаггүй	Улаанбаатар хотын бөөний төвүүд баримт өгдөггүй	Баримт авбал үнийн дүн нэмнэ гэдэг	Гаалиар орж ирсэн бараанд баримтаа авч чаддаггүй	
Та ямар чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг вэ?	А. Сүү цагаан идээ болон мах махан бүтээгдэхүүний худалдаа	0	17	0	0	0	17
	В. Хүнсний ногооны худалдаа	0	24	0	0	0	24
	С. Барилгын материалын худалдаа	1	17	5	0	7	30
	Бэлэн хувцасны худалдаа	0	10	19	18	10	57
	Гоо сайхны худалдаа	0	2	4	4	0	10
	Онлайн дэлгүүрийн худалдаа	0	0	2	3	5	10
	Бусад	0	0	1	1	0	2
<b>Total</b>		1	70	31	26	22	150

*Эх сурвалж: Судлаачийн тооцоолол*  
Судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчдийн 47%(70) нь худалдан авалтын баримтаа авч чаддаггүй гэж хариулсан бөгөөд сүү цагаан идээ, хүнсний ногоо худалдаачид бүгд төлбөрийн баримтаа авч чаддаггүй гэж хариулжээ. Хангалттай баримтаа авч чаддаг гэж хариулсан 1 бизнес

эрхлэгч байгаа нь цаашид худалдан авалтын баримтыг олгох тал дээр татварын алба анхаарч ажиллах шаардлагатайг харуулж байна.

6. Төлбөрийн баримтыг хэрэглэгчдэд олгож байгаа эсэх, ямар аргаар олгож байгааг тодорхойлоо.

*Хүснэгт 6. Татвар төлөгчдийн төлбөрийн баримт олгож байгаа байдал*


Үзүүлэлт		Та төлбөрийн баримтыг борлуулалт бүртгээ олгож байгаа юу?				Total
		Тийм	Худалдан авагч асуувал өгдөг	Хаяадаа	Огт төлбөрийн баримт олгодоггүй	
<b>Та төлбөрийн баримтаа яаж олгодог вэ?</b>	Посс машин, хэвлэж өгдөг	16	1	2	1	20
	QR наалт	22	21	22	3	68
	Утасны дугаараар мессежээр явуулдаг	5	3	3	0	11
	Бусад	0	1	1	49	51
<b>Total</b>		43	26	28	53	150

*Эх сурвалж: Судлаачийн тооцоолол*

Нийт бизнес эрхлэгчдийн 35% (53) нь төлбөрийн баримт олгохгүй байгаа бөгөөд татвар төлөгч биш бизнес эрхлэгчдийг татвар төлөгчөөр бүртгэхэд анхаарч ажиллах, мөн худалдан авагч асуувал өгдөг, хаяадаа өгдөг гэж хариулсан татвар төлөгчдийг илрүүлж тогтмол өгдөг болгох тал дээр анхаарч ажиллах шаардлагатай.

**Хоёр.** Татвараас зайлсхийх хандлагыг тодорхойлохдоо Хэсэгчилсэн хамгийн бага квадрат (PLS) бүхий бүтцийн тэгшитгэлийн загвар (SEM) дээр суурилан Warp PLS 7.0 программыг ашиглан гаргасан байна. Бидний Зураг 1-д тодорхойлсон загварыг дагуу тодорхойлсон таамаглалуудын үр дүн 150 бизнес эрхлэгчээс авсан судалгаагаар дараах байдалтай байна. Судалгааны дэлгэрэнгүйг хавсралт хэсгээс харна уу.

*Зураг 2. Татвар төлөгчдийн татвараас зайлсхийх хандлагын загвар /Орхон аймгийн жишээн дээр/*



*Эх сурвалж: Судлаачийн тооцоолол*

- ✓ **Таамаглал 1** (H1) - Татварын шударга байдал (FP) нь татвараас зайлсхийх хандлага (ATE) -д сөргөөр нөлөөлдөг таамаглалын үр дүн: Замын коэффициент  $\beta = -0.07$  байгаа нь татварын шударга байдал татвараас зайлсхийхэд сөрөг нөлөөтэй байгааг баталж байгаа хэдий ч хамаарлын хүч сул, магадлалын утга  $\rho = 0.18$  байгаа нь энэ таамаглал үгүйсгэгдэж байна. Өөрөөр хэлбэл татварын шударга байдал татвараас зайлсхийхэд нөлөөгүй байна.
- ✓ **Таамаглал 2** (H2) – Ялгаварлан гадуурхах байдал (D) нь татвараас зайлсхийх хандлага (ATE) -д дэмжих нөлөөтэй таамаглалын үр дүн: Замын коэффициент  $\beta = 0.18$  байгаа нь татварын шударга байдал татвараас зайлсхийхэд эерэг нөлөөтэй байгааг баталж байгаа бөгөөд, магадлалын утга

- $\rho < 0.01$  байгаа нь энэ таамаглал батлагдаж байна. Татварын ялгаварлан гадуурхах байдал нь хүчтэй биш ч нөлөөтэй байгаа нь ажиллагдаж байна.
- ✓ **Таамаглал 3** (Н3) - Авлига (С) нь татвараас зайлсхийх хандлага (АТЕ) -д нөлөөтэй таамаглалын үр дүн: Замын коэффициент  $\beta = 0.08$  байгаа нь авлига татвараас зайлсхийхэд эерэг нөлөөтэй байгааг баталж байгаа хэдий ч хамаарлын хүч сул, магадлалын утга  $\rho = 0.18$  байгаа нь энэ таамаглал үгүйсгэгдэж байна. Өөрөөр хэлбэл авлига татвараас зайлсхийхэд нөлөөгүй байна.
  - ✓ **Таамаглал 4** (Н4) - Татварын мэдлэг (ТК) нь татвараас зайлсхийх хандлага (АТЕ) -д сөрөг нөлөөтэй таамаглалын үр дүн: Замын коэффициент  $\beta = 0.21$  байгаа нь татварын мэдлэг татвараас зайлсхийхэд эерэг нөлөөтэй байгаа бөгөөд бидний таамаглалын эсрэг үр дүн гарч байна. Магадлалын утга  $\rho < 0.01$  байгаа нь татварын мэдлэгтэй байх нь татвараас зайлсхийх хандлагад эерэг нөлөө үзүүлж байна гэсэн дүгнэлтэд хүрч байна.
  - ✓ **Таамаглал 5** (Н5) - Татварын тогтолцооны нарийн төвөгтэй байдал (СТS) нь татвараас зайлсхийх хандлага (АТЕ) -д эерэг нөлөө үзүүлдэг гэсэн таамаглалын үр дүн: Замын коэффициент  $\beta = 0.12$  байгаа нь татварын тогтолцооны нарийн төвөгтэй байдал нь татвараас зайлсхийхэд эерэг нөлөөтэй байгааг баталж байна,  $\rho = 0.07$  байгаа нь энэ таамаглал 93%-ийн магадлалтай батлагдаж байна.
  - ✓ **Таамаглал 6** (Н6) - Татварын хяналт шалгалт хийх (АР) нь татвараас зайлсхийх хандлага (АТЕ) -д сөрөг нөлөөтэй таамаглалын үр дүн: Замын коэффициент  $\beta = -0.08$  байгаа нь татварын хяналт шалгалт нь татвараас зайлсхийхэд сөрөг нөлөөтэй байгааг баталж байна,  $\rho = 0.16$  байгаа нь энэ таамаглалыг үгүйсгэж байна. ХХОАТ төлөгчдийн хувьд татварын хяналт шалгалт татвараас зайлсхийх хандлагад нөлөөлөхгүй байгаа нь жижиг худалдаа эрхлэгчдийн хувьд татварын хяналт шалгалт хийдэггүйтэй холбоотой.
  - ✓ **Таамаглал 7** (Н7) - Татварын албаны хэрэгжүүлж буй ажлууд (ЕI) нь татвараас зайлсхийх хандлага (АТЕ) -д сөрөг нөлөөтэй таамаглалын үр дүн: Замын коэффициент  $\beta = 0.19$  байгаа нь татварын албаны хэрэгжүүлж буй ажлууд нь татвараас зайлсхийхэд эерэг нөлөөтэй байгааг баталж бидний таамаглал үгүйсгэгдэж байна,  $\rho < 0.01$  байгаа нь эерэг хамаарлыг 99%-ийн магадлалтай хүлээн зөвшөөрч байна. Татварын албаны хэрэгжүүлэх нөхөн татвар, хүү, торгуул зэрэг нь татвар төлөгчдөд дарамт болдоггүй нь харагдаж байна.

- ✓ Таамаглал 8 (H8) - Татварын байгууллагын үр ашиг (ТАЕ) нь татвар төлөгчдийн татвараас зайлсхийх хандлагад сөрөг нөлөөтэй таамаглалын үр дүн: Замын коэффициент  $\beta=0.08$  байгаа нь татварын албаны хэрэгжүүлж буй ажлууд нь татвараас зайлсхийхэд эерэг нөлөөтэй байгааг баталж бидний таамаглал үгүйсгэгдэж байгаа ч  $\rho=0.17$  байгаа энэ үзүүлэлт нь татвараас зайлсхийхэд нөлөөгүй байгааг илэрхийлж байна.

Бид энэхүү судалгаандаа татвар төлөгчдийн татвараас зайлсхийх хандлагад нөлөөлж буй хүчин зүйлсийг судлах зорилгыг хэрэгжүүлсэн бөгөөд таамаглалын сорилд үндэслэсэн энэхүү судалгааны үр дүнгээс харахад шударга ёсны талаарх ойлголт, авлига, татварын хяналт шалгалт, хяналт шалгалтын дараа татварын албаны хэрэгжүүлж буй ажлууд, татварын байгууллагын үр ашиг зэрэг нь татвараас зайлсхийхэд нөлөөгүй гэсэн дүгнэлтэд хүрч байна.

Татварын ялгаварлан гадуурхалт, татварын мэдлэг, татварын тогтолцооны нарийн төвөгтэй байдал зэрэг нь татвараас зайлсхийхэд нөлөөтэй байна.

Судалгааны үр дүнгээс харахад судалгаанд хамрагдсан иргэдийн бизнесийн үйл ажиллагаанд хяналт, шалгалтыг хэрэгжүүлдэггүй, тэднийг орлогоо нуун дарагдуулсан эсэхийг тогтоох боломжгүй байдаг зэрэг нь бидний сөрөг нөлөөтэй гэж үзсэн үзүүлэлтүүд нөлөөгүй гэж гарахад хүргэжээ.

## ДҮГНЭЛТ

Татвараас зайлсхийх хандлагад нөлөөлөх хүчин зүйлсийг Харун Ур Рашидын тодорхойлсон загвард суурилсан бөгөөд татварын шударга байдал, татварын мэдлэг, татварын хяналт шалгалт хийх, татварын албаны хэрэгжүүлж буй ажлууд, татварын байгууллагын үр ашиг зэрэг нь татвараас зайлсхийх хандлагад сөрөг нөлөөтэй, ялгаварлан гадуурхах байдал, авлига, татварын тогтолцооны нарийн төвөгтэй байдал зэргийг татвараас зайлсхийх хандлагад эерэг нөлөөтэй гэж загварчилсан. Бид судалгаандаа ОРХОН аймгийн хувиараа бизнес эрхлэгч 150 иргэдийн татвараас зайлсхийх хандлагад дээрх хүчин зүйлүүд хэрхэн нөлөөлж байгааг Хэсэгчилсэн хамгийн бага квадрат (PLS) бүхий бүтцийн тэгшитгэлийн загвар (SEM) дээр суурилан Warp PLS 7.0 программыг ашиглан гаргасан байна.

Судалгааны үр дүнд Харун Ур Рашидын тодорхойлсон үзүүлэлтээс шударга ёсны талаарх ойлголт, авлига, татварын хяналт шалгалт, хяналт шалгалтын дараа татварын албаны хэрэгжүүлж буй ажлууд, татварын байгууллагын үр ашиг зэрэг үзүүлэлтүүд Орхон аймгийн ХХОАТ төлөгч иргэдийн татвараас зайлсхийх хандлагад нөлөөгүй гэж тодорхойлогдлоо.

Харин татварын ялгаварлан гадуурхалт, татварын мэдлэг, татварын тогтолцооны нарийн төвөгтэй байдал зэрэг нь татвараас зайлсхийхэд эерэг нөлөөтэй байна. Иймээс цаашид татвар төлөгчдийг ялгаварлан гадуурхах сэтгэгдэл төрүүлэхгүй, хүмүүсийн шашин шүтлэг, арьс өнгө, орлогын хэмжээ зэргээр ялгаварлан гадуурхахгүй байх тал дээр анхаарч ажиллах шаардлагатай. Татвар төлөгч татварын мэдлэгтэй байх нь татвараас зайлсхийхэд эерэг нөлөөтэй байгаад анхаарч татварын тогтолцоог татвараас зугтах боломжгүй, хуулийн дагуу хэрэгжүүлэхээр зохион байгуулах, болон татварын тайлагналын нарийн төвөгтэй байдлыг хялбарчилж, тайлагналын арга зүйг сайн мэдээлж байх шаардлагатай.

Тус судалгаанд бизнес эрхлэгчдийн хүн ам зүйн шинжийг харгалзан судалсан бөгөөд татвараас зайлсхийх хандлагад нөлөөлөх шууд хамаарлыг судлаагүй болно. Нийт судалгаанд оролцогчдын 70% нь эмэгтэйчүүд бөгөөд тайлангаа илгээгүй бизнес эрхлэгчдийн 76% нь эмэгтэйчүүд байна. Иймээс татвараас зайлсхийхэд хүйсийн байдал нөлөөгүй гэж дүгнэлээ. Бизнес эрхлэгчдийн 40% нь дээд боловсролтой бөгөөд эдгээрийн дийлэнх нь өөрөө тайлангаа гаргаж илдээг гэж хариулсан байна. Харин суурь, болон бүрэн дунд боловсролтой бизнес эрхлэгчдийн 46% нь тайлан гаргадаггүй гэж хариулсан байна. Иймээс татвараас зайлсхийх хандлагад боловсролын түвшин дээшлэх нь эерэг нөлөөтэй байна.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Chan Pui Yee, K. M. (2017). Taxpayers' perceptions on tax evasion behaviour: an empirical study in Malaysia. *International Journal of Law and Management*.
- Fadi Al-Asfour, K. A. (2023). Tax ethics and tax compliance: evidence from emerging markets. *Corporate Governance and Organizational Behavior Review*.
- Harun Ur Rashid. (2020, 4-6). Taxpayer's Attitude Towards Tax Evasion in a Developing Country: Do the Demographic Characteristics Matter? *International Journal of Applied Behavioral Economics*, 9(2).
- Marziana Mohamad, N. M. (2013). Accounting vs non-accounting majors: perception on tax knowledge, fairness and perceived behavioural control. *International Journal of Asian Social Science*. Retrieved from [https://www.researchgate.net/publication/327593666\\_Accounting\\_vs\\_Non\\_Accounting\\_Majors\\_Perceptions\\_on\\_Tax\\_Knowledge\\_Fairness\\_and\\_Perceived\\_Behavioural\\_Control](https://www.researchgate.net/publication/327593666_Accounting_vs_Non_Accounting_Majors_Perceptions_on_Tax_Knowledge_Fairness_and_Perceived_Behavioural_Control)



- Musimenta, D. (2020). Knowledge requirements, tax complexity, compliance costs and tax compliance in Uganda. *Cogent Business & Management*.
- Paul H. P. Hanel, C. F. (2024). Attitudes and Values. *Oxford Research Encyclopaedia of Psychology*.
- Richardson, G. (2016). The Determinants of Tax Evasion: A Cross-Country Study. doi:10.1007/978-3-319-32419-7\_2
- Sajjad Ahmad Baig, M. Z.-u.-R. (2023). Impact of Quality Management Practices on Performance: Moderating Role of Innovation Culture. <https://www.researchgate.net/publication/328096646>.
- Susanna Calimani, a. P. (2014). Tax enforcement in an agent-based model with. *Lecture Notes in Economics and Mathematical Systems*. doi:10.1007/978-3-319-00912-4\_4
- Г.Алтанзаяа. (2023). *Татварын бүртгэл* .
- Г.Сарангэрэл, Ц. (2012). Татварын боловсролын өнөөгийн байдал ба цаашид сайжруулах арга зам. *Татварын ерөнхий газар*. Retrieved from [https://cdn.mta.mn/2muG1RE5Qkqd\\_R59a8zy-Q/mta.mn/](https://cdn.mta.mn/2muG1RE5Qkqd_R59a8zy-Q/mta.mn/)
- Г.Хишигсүрэн. (2022). Татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн эрх зүйн зохицуулалт ба харьцуулсан судалгаа. *Диссертацийн ажил*.
- Л.Буяндулам, Т. (2019). Татварын хуулийн хэргэжилтэд нөлөөлөх хувь. *Бизнес Инноваци*. Retrieved from <https://journal.num.edu.mn/BusinessAndInnovation/article/download/2358/2079/5732>
- Марк Саксер. (2020). *Өөрчлөлтийн нийгэм дэх авлигатай тэмцэх нь. Фридрих-Эбертийн Сангийн Монгол Улс дахь суурин төлөөлөгчийн газар*.
- Монгол банк. (2019). *sankhuuginbolovsrol.mn*. Retrieved from Санхүүгийн боловсрол.
- Нээлттэй нийгэм форум. (2023). *Хувь хүний орлогын албан татварт хамрагдаж буй орлогын эх үүсвэрүүд Монгол улс болон олон улсын туршлагауд*. Улаанбаатар.
- Орхон аймгийн Татварын хэлтэс. (2023). ХХОАТ-ын тайлангийн мэдээ.
- Татварын ерөнхий газар. (2023). Retrieved from <https://mta.gov.mn/>: <https://mta.gov.mn/subscribe>